

Хяналт шалгалт хийсэн  
тухай

**Хяналт шалгалтын зорилго**

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, Булган аймгийн Засаг даргын баталсан 2017 оны 05 сарын 22-ны өдрийн 1/14 дүгээр удирдамжийн дагуу Санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон бусад холбогдох дүрэм, журам, тушаалуудын хэрэгжилтийг хангуулж, үндсэн үйл ажиллагааны байдал, зохион байгуулалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааны байдлыг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгч, ололт амжилтыг бататгаж, зөрчил дутагдлыг арилгахад чиглэгдэнэ.

**Шалгалтанд хамрагдсан байгууллага, бүрэлдэхүүн, хугацаа**

Хутаг-Өндөр сумын Соёлын төвийн 2015, 2016 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ж.Оюун 2017 оны 05 сарын 23-аас хуанлын 7 хоногийн хугацаанд багтаан гүйцэтгэв.

**Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, шалтгаан**

1. Анхан шатны баримтуудыг дугаарлаагүй, хөтлөгдвөл зохих анхан шатны баримтуудаас бэлэн мөнгөний орлого, зарлагын баримт, үндсэн хөрөнгө хүлээн авах, шилжүүлэх баримт, бараа материалын тооцоо бодсон акт зэргийг огт хөтлөөгүй, үндсэн хөрөнгө, шатахууны тайлан гаргаагүй, авсан шатахууны хэмжээгээр зардалд тусгадаг, бараа материалын тайланг буруу гаргасан, ихэнх шаардах хуудаст зөвшөөрсөн, олгосон тоо хэмжээг тавиагүй, гарын үсгийн бүрдэл дутуу зурагдсан, аж ахуйн материалын тайланд бичиг хэрэг, цэвэрлэгээ, засварын материалыг тусгасан, эд хөрөнгийн тооллогын бүртгэлд нийт хөрөнгийн дүнг тавьдаггүй, ажлын цаг ашиглалтын бүртгэлийг тухай бүр хөтөлдөггүй, цаг бүртгэгчийн гарын үсэг зурагдаагүй, ажлын цагийн тооцоог үндэслэж цагийн бүртгэл гаргаагүй, байгууллагын дотоод журмыг хамт олны хурлаар хэлэлцүүлж батлуулаагүй, цалин олгох болон гарт олгох хүснэгтэд ажиллагсдын гарын үсэг зурагдаагүй, 2015 онд бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.6 дахь заалт, Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалаар батлагдсан зааврыг зөрчсөн.

2. Тус сумын Соёлын төв нь 2015 оны 1-3, 6, 11-12 сар, 2016 оны 9-11 саруудад 6 орон тоотой ажилласан, Хутаг-Өндөр сумын Засаг даргын 2014 оны 10 сарын 27-ны өдрийн А/140 дугаар “Цалин шинэчлэн тогтоох тухай” захирамжийг үндэслэн эрхлэгч

Н.Алтанцэцэгийн ажлыг шалгуур үзүүлэлтээр нь үнэлж дүгнэлгүй тогтмол нэмэгдэл мэтээр сар бүр үндсэн цалингийн 10 хувиар тооцож 2015 оны 1-7, 11-12 саруудад 465.1 мянган төгрөг, 2016 оны 1-12 саруудад 683.7 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл цалин, Соёлын төвийн эрхлэгчийн 2015 оны 09 сарын 02-ны өдрийн Б/12 дугаар тушаалаар Хөдөлмөрийн тухай хуулийн 21.1 дэх заалтыг үндэслэн номын санч Б.Наранчимэгт орон тоонд батлагдаагүй архив, бичиг хэргийн эрхлэгчийн ажлыг хавсруулан үндсэн цалингийн 15 хувиар тооцож 9, 10 сард 134.0 мянган төгрөгийн нэмэгдэл цалин, эрхлэгчийн 2016 оны 01 сарын 04-ний өдрийн Б/04 дүгээр тушаалаар Хөдөлмөрийн тухай хуулийн 50.2 дахь заалтыг үндэслэн техникч Ц.Чулуунбатад орон тоонд батлагдаагүй няравын ажлыг хавсруулан үндсэн цалингийн 10 хувиар тооцож 1-12 сард 504.2 мянган төгрөгийн нэмэгдэл цалин тус тус олгосон нь Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д /Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд: батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;/, мөн хуулийн 16.5.5-д /Төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна./, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./, Засгийн газрын 1995 оны 96 тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 4-т /Ур чадварын нэмэгдлийг олгох, олгож байгаа нэмэгдлийн хэмжээг нэмэгдүүлэх, бууруулах, хасах асуудлыг энэ журмын 2,8-д заасан шалгуурыг үндэслэн тухайн байгууллагын эрх баригчийн тушаалаар шийдвэрлэнэ/ заасан заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй.

**3.** Бараа материалын хөдөлгөөн, үлдэгдлийн бүртгэлийг огт хөтлөөгүй нь Сангийн сайдын 2000 оны 69 тоот тушаалаар баталсан “Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм”-ийн 14-д /Хадгалж байгаа зүйлийг нэр төрөл, үнэ, зэрэг дугаараар нь ангилан төрөлжүүлж хураан агуулахын үлдэгдлийн бүртгэлийг зохих маягт зааврын дагуу тогтмол хөтөлж байна. / заасан заалтыг зөрчсөн.

**4.** Үзвэрийн орлогын төлбөрийг “Бэлэн мөнгөний орлогын баримт”-аар хүлээн авдаггүй, тоглолтын билет хэрэглэж байгаа ч тайлан гаргаагүй, үндсэн үйл ажиллагааны орлогоос төрийн сангийн бүртгэлийн дансанд тушаалгүй уран бүтээлчдийн урамшуулал, өргөмжлөл, дурсгалын зүйлд зарцуулдаг.

**5.** Эрхт түшиг ХХК-иас хандивласан 3000.0 мянган төгрөгөөс цахилгааны монтаж, халаалтын систем байршуулах, сангийн засвар хийлгэх ажлын хөлсөнд 800.0 мянган төгрөг олгосон ч санхүүгийн тайланд бараа материалын тайланд тусгасан.

**6.** Сахилгын шийтгэлийг үндсэн цалингаас бус суутгаж тооцсон.

**7.** 2005 онд үүссэн 92.4 мянган төгрөгийн авлагыг одоог хүртэл барагдуулаагүй байна.

**8.** Сэлэнгэ сумын хөтөл багийн иргэн Ю.Зоригоотой сургуулийн 24 хүүхдэд цэнгээнт бүжиг заалгахаар хамтран ажиллах нэг сарын гэрээ байгуулж ажлын хөлсөнд 225.0 мянган төгрөг, сумын иргэн Х.Мөнхбаяртай эрхлэгчийн өрөөнд урсгал засвар хийлгэхээр гэрээ байгуулж ажлын хөлсөнд 270.0 мянган төгрөг, 2015 оны 08 сарын 10-аас 30-ны өдрийг дуустал сумын иргэн Л.Халиунтай архив, бичиг хэргийн ажлыг гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж 270.0 мянган төгрөг, сумын иргэн Н.Энхцэцэгтэй хөгжмийн багшийн ажлыг 2015 оны 09 сарын 02-оос 2 сарын хугацаатай

гүйцэтгүүлэхээр хамтран ажиллах гэрээ байгуулж ажлын хөлсөнд 540.0 мянган төгрөг, сумын иргэн Ц.Мягмарсүрэнтай 2015 оны 10 сарын 16-аас 5 хоногийн хугацаанд сантехникийн эвдрэл гэмтлийг засуулахаар гэрээ байгуулж ажлын хөлсөнд 270.0 мянган төгрөг, мөн 2015 оны 12 сарын 20-ны өдрийн 30-ныг дуустал сангийн засварын ажлыг хийлгэхээр гэрээ байгуулж ажлын хөлсөнд 585.0 мянган төгрөг, 2015 оны 11 сард сумын иргэн Б.Ганбаатартай хөгжмийн өрөөний таазны урсгал засвар хийлгэхээр гэрээ байгуулж ажлын хөлсөнд 315.0 мянган төгрөг, мөн иргэн Алтан-Өлзийтэй тус төвийн соль гэрлийн эвдэрлийг засварлуулахаар гэрээ байгуулж ажлын хөлсөнд 81.0 мянган төгрөг зарцуулсан ч гүйцэтгэлийг нотлох баримт, хүлээн авсан актгүй зарцуулсан байна.

### **Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгсөн байдал**

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 7 заалттай 1 албан шаардлага үйлдэж, улсын байцаагчийн 2 актаар 629.6 мянган төгрөгийн төлбөр тогтоов.

### **Дүгнэлт**

Анхан шатны баримтуудыг дугаарлаагүй, сайдын тушаалаар батлагдсан анхан шатны баримтуудыг бүрэн хөтлөөгүй, анхан шатны баримтуудын гарын үсгийн бүрдэл дутуу, ажлын цаг ашиглалтын бүртгэлийг тухай бүр тогтмол бүртгэж хэвшээгүй, бараа материалын хөдөлгөөн, үлдэгдлийн бүртгэлийг хөтлөөгүй, бараа материалын тайланг буруу гаргасан зэрэг нь байгууллага дотооддоо бүртгэлээр тавих дотоодын хяналтыг хэрэгжүүлээгүй, сулруулсан байна гэж дүгнэлээ.

### **Цаашид авах арга хэмжээний санал**

- Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийг уншиж судлаж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх
- Дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх
- Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу албан ёсны баримтыг үндэслэн зарцуулж байх
- Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоож, давтан гаргахгүй байхаар тодорхой ажил зохион байгуулж, акт, албан шаардлагын биелэлтийг хангах

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ

Ж.ОЮУН



